



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/45

Шивээговь сум

0-12 насны хүүхэдтэй ажилтан, албан хаагчдад цалинтай чөлөө олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, 29.1.6.а, б, л, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 64 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 06 дугаар тогтоол “Иргэд, зорчигч тээврийн хөдөлгөөнийг хязгаарлах тухай”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Коронавируст халдвар тархахаас урьдчилан сэргийлэх, бага насны хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон орон нутгийн өмчит газрын жирэмсэн болон 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй ажилтан, албан хаагчийг 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд гэрээсээ ажиллах нөхцөл боломжоор хангаж, цалинтай чөлөө олгохыг байгууллагын удирдлагуудад зөвшөөрсүгэй.

2. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр зохион байгуулж, чөлөөлөгдсөн ажилтан, албан хаагчдын цалин хөлсийг ажилласанд тооцож олгохыг байгууллагын удирдлагуудад даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч, онцгой комиссын гишүүн /Ж.Батмөнх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

4212 0106